



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/185/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас:327734 Цахим хаяг: Nandinjargalg@audit.gov.mn Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn Аудитор: Т.Гандолгор Утас: 325093 Цахим хаяг: gandolgort@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-08-05 № 338
танай _____-ны № _____-т

НАЛУУ-УХАА ЭДИЙН ЗАСГИЙН
ТУСГАЙ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Д.ОТГОНСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн захирагчийн ажлын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/118 дугаар захирамжаар Налуу-Ухаа Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тооны хязгаарыг баталсан байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

1426050403

C:\Users\mranqaa\Documents\Бичиг хэргэ\2026\2026\word\wyaan_bichig\2026.02.25 Dugnell - docx

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	00.00	3,206,067.00
35	БАРАА МАТЕРИАЛ	00.00	3,206,067.00
354	Хангамжийн материал	00.00	3,206,067.00
35410	Бичиг хэргийн материал	00.00	1,769,467.00
35420	Аж ахуйн материал	00.00	721,050.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	126,500.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	589,050.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	00.00	91,832,883.41
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	00.00	91,832,883.41
392	Биет хөрөнгө	00.00	90,182,883.41
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	00.00	71,912,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-18,450,299.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	00.00	38,819,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-2,098,616.62
39301	Програм хангамж	00.00	1,650,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	00.00	95,038,950.41
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	00.00	95,038,950.41
51	Засгийн газрын хувь оролцоо	00.00	95,038,950.41
512	Хуримтлагдсан үр дүн	00.00	95,038,950.41
51210	Өмнөх үеийн үр дүн		
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	95,038,950.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	00.00	95,038,950.41

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	00.00	675,113,420.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	70,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	70,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	675,043,420.97
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	675,043,420.97
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	675,043,420.97
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	00.00	580,074,470.56

21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	580,074,470.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	580,074,470.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	186,647,746.64
210101	Үндсэн цалин	00.00	117,108,215.73
210102	Нэмэгдэл	00.00	16,249,650.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	50,855,000.00
210104	Урамшуулал	00.00	2,434,880.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	23,059,443.83
210201	Тэтгэврийн даатгал	00.00	15,865,058.46
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,804,227.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	902,113.73
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	872,708.83
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	3,615,335.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	103,800,000.00
210304	Байрны түрээс	00.00	103,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	11,588,338.00
210401	Бичиг хэрэг	00.00	2,174,490.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	4,535,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	3,849,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	1,029,398.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	6,713,539.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	6,713,539.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	227,716,486.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	187,380,736.50
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	40,053,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	282,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	20,548,916.59
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	00.00	20,548,916.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	95,038,950.41
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	00.00	95,038,950.41

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	00.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	70,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	70,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	70,000.00

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	675,043,420.97
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	675,043,420.97
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	675,043,420.97
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	00.00	562,731,620.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	562,731,620.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	562,731,620.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	186,647,746.64
210101	Үндсэн цалин	00.00	117,650,666.13
210102	Нэмэгдэл	00.00	16,024,773.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	50,537,427.50
210104	Урамшуулал	00.00	2,434,880.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	23,059,443.83
210201	Тэтгэврийн даатгал	00.00	15,865,058.46
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,804,227.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	902,113.73
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	872,708.83
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	3,615,335.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	103,800,000.00
210304	Байрны түрээс	00.00	103,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	14,525,005.00
210401	Бичиг хэрэг	00.00	3,943,957.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	4,535,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	3,849,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	2,196,598.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	269,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	269,400.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	4,150,339.00
210702	Дотоод албан томилолт	00.00	4,150,339.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	230,279,686.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	189,943,936.50
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	40,053,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	282,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,375,000.00	3,930,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,930,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,375,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	112,381,800.00

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	112,381,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	112,381,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	112,381,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	112,381,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-112,381,800.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	95,038,950.41	00.00	95,038,950.41
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	95,038,950.41	00.00	95,038,950.41

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,244,684,100.00	675,113,420.97	569,570,679.03	54.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,244,684,100.00	675,113,420.97	569,570,679.03	54.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,244,684,100.00	675,113,420.97	569,570,679.03	54.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	434,915,900.00	186,647,746.64	248,268,153.36	42.92
210101	Үндсэн цалин	191,887,100.00	117,650,666.13	74,236,433.87	61.31
210102	Нэмэгдэл	123,077,400.00	16,024,773.01	107,052,626.99	13.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	84,700,000.00	50,537,427.50	34,162,572.50	59.67
210104	Урамшуулал	35,251,400.00	2,434,880.00	32,816,520.00	6.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,062,800.00	23,059,443.83	40,003,356.17	36.57
210201	Тэтгэврийн даатгал	36,967,900.00	15,865,058.46	21,102,841.54	42.92
210202	Тэтгэмжийн даатгал	4,349,200.00	1,804,227.48	2,544,972.52	41.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,177,600.00	902,113.73	11,275,486.27	7.41
210204	Ажилгүйдлийн даатгал	869,800.00	872,708.83	-2,908.83	100.33
210205	Эрүүл мэндийн даатгал	8,698,300.00	3,615,335.33	5,082,964.67	41.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,000,000.00	103,800,000.00	1,200,000.00	98.86
210301	Гэрэл, цахилгаан	4,200,000.00	00.00	4,200,000.00	0.00
210304	Байрны түрээс	100,800,000.00	103,800,000.00	-3,000,000.00	102.98
2104	Хангамж, бараа материалын зардал	45,309,900.00	14,525,005.00	30,784,895.00	32.06
210401	Бичиг хэрэг	14,005,000.00	3,943,957.00	10,061,043.00	28.16
210402	Тээвэр, шатахуун	3,105,900.00	4,535,100.00	-1,429,200.00	146.02
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,625,000.00	3,849,350.00	7,775,650.00	33.11
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,574,000.00	2,196,598.00	14,377,402.00	13.25
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	155,130,100.00	111,001,200.00	44,128,900.00	71.55
210601	Багаж, техник, хэрэгсэл	105,992,100.00	72,182,200.00	33,809,900.00	68.10
210602	Тавилга	40,178,000.00	38,819,000.00	1,359,000.00	96.62
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,960,000.00	00.00	8,960,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	10,020,000.00	4,150,339.00	5,869,661.00	41.42
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	10,020,000.00	4,150,339.00	5,869,661.00	41.42
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	431,245,400.00	231,929,686.50	199,315,713.50	53.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	350,000,000.00	189,943,936.50	160,056,063.50	54.27

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000,000.00	00.00	7,000,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	296,500.00	00.00	296,500.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	169,900.00	00.00	169,900.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	400,000.00	00.00	400,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	65,879,000.00	41,703,000.00	24,176,000.00	63.30
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,500,000.00	00.00	2,500,000.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,000,000.00	282,750.00	4,717,250.00	5.66
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,244,684,100.00	675,113,420.97	569,570,679.03	54.24
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,244,684,100.00	675,043,420.97	569,640,679.03	54.23
132001	Орон нутгийн төсвөөс	1,244,684,100.00	675,043,420.97	569,640,679.03	54.23
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	70,000.00	-70,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	70,000.00	-70,000.00	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,987.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 3,005.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 4,982.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ангилал буруу бүртгэсэн 634.8 мянган төгрөг, бараа материалыг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн 589.05 мянган төгрөгийг	1	1,223.9			1	1,223.9	1	1,223.9				
Хөрөнгийн элэгдэл илүү тооцсон тооцсонг	1	2,129.8			1	2,129.8	1	2,129.8				
Бараа материалыг зардалд бөөн дүнгээр бүртгэсэнг	1	2,852.2			1	2,852.2	1	2,852.2				
Дүн	3	6,205.9			3	6,205.9	3	6,205.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жилийн эцсийн тооллого хийхдээ өмч хамгаалах комисс байгуулж дүгнэлт гаргаж байх	1							1				
Байгууллагын дарга тухайн жилийн орон тоо, бүтцийг хууль тогтоомжид заасан хугацаанд батлаагүй, батлагдаагүй орон тоонд үндэслэн хүний нөөцийн бүрдүүлэлт, цалин хөлс олгосон, дотоод хяналтын тогтолцоо сул, холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангаагүй байна.	1							1				
Зочид төлөөлөгчийн хүлээн авсан зардлыг ажилтаны дансруу шилжүүлсэн байна.	1	1,437.6	1	1,437.6								

ВАЙЛД РЕЗОРТ Хурлын заалны түрээслэн хурал зохион байгуулсан байна.	1	1,568.0	1	1,568.0							
Ажлыг ажилтанд хавсруулан гүйцэтгүүлж, 2,365,040.0 төгрөгийн нэмэгдэл олгосон зөрчил илэрсэн байна. / Ажлын тайланд үндэслэн олгоогүй байна /	1	2,365.0			1	2,365.0					
Ажилтан, албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийн карт нээгээгүй, эд хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтгүй байна	1						1				
Сар бүрийн бараа материалын орлого, зардлын дүнгээр анхан шатны баримт бүрдүүлж няравын тайланг бэлтгээгүй, нягтлан бодогч хянаж баталгаажуулаагүй байна.	1	2,617.0			1	2,617.0					
Дүн	7	7,987.7	2	3,005.6	2	4,982.1	3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажлын даалгаваргүйгээр 66,890.0мянган төгрөгийн гэрээ байгуулан төлбөрийг шилжүүлсэн, иргэнээс гарээ байгуулахгүйгээр 3,135.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн, мөн тэдгээрийн ажлын тайлан байхгүй байна. Хөлсөөр ажиллах гэрээг дүгнэлгүйгээр санхүүжилт олгосон, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй санхүүжилтийг бүрэн олгосон байна.	1	89,573.7					1	89,573.7
Зөвлөх үйлчилгээ болон хуулийн зөвлөх үйлчилгээг зөвлөх үйлчилгээний эрхгүй хувь хүнтэй гэрээ хийсэн байна.	1	40,800.0			1	40,800.0		
Байгууллагын веб сайт хийлгээд хүлээж аваагүй гэрээ дүгнэсэн акт үйлдэж төлбөрийг шилжүүлсэн байна.	1	19,900.0			1	19,900.0		
Дуудлагын автобазаас автомашин түрээслэх боломжтой байсан ч хувь хүнтэй гэрээ хийсэн, автобазаас машин дуудлагаар унаж тушаал шийдвэргүй зардал гарган төсвийг үрэлгэн зарцуулсан байна.	1	6,885.1			1	6,885.1		
Үндсэн хөрөнгө худалдан авахдаа харьцуулсан үнийн судалгаагүй, гэрээ байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн.	1	112,970.9			1	112,970.9		

Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш орлогын 1,122,313.58 мянган төгрөгийн 8 гүйлгээг, 5 сая төгрөгөөс дээш зарлагын 295,514.00 мянган төгрөгийн 19 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, 15 шийдвэрийг мэдээлээгүй байна.	1					1	
Дүн	6	270,129.7		4	180,556.00	2	89,573.7



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 484/А0230344

Улаанбаатар хот

НТАГ-2026/185/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгө худалдан авахдаа харьцуулсан үнийн судалгаагүй, гэрээ байгуулаагүй 112,970,850.00 (нэг зуун арван хоёр сая есөн зуун далан мянга найман зуун тавь) төгрөгийн шууд худалдан авалт хийсэн, холбогдох хууль тогтоомжийг мөрдөөгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д "Худалдан авах ажиллагаа шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 33.1-д "Бараа ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгө худалдан авахдаа харьцуулсан үнийн судалгаагүй, гэрээ байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны дарга Д.Отгонсүрэн, нягтлан бодогч А.Батжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Т.ГАНДОЛГОР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090897



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 182/А0220544

Улаанбаатар хот

НТМ-2026/185/ММ-ЦН-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хувь хүнтэй гэрээ хийж авто машин түрээслэсэн, төрийн автобаазаас дуудлагаар тээврийн хэрэгсэл ашиглахдаа анхан шатны баримтын бүрдэл дутуу зардал гарган 6,885,100.00 (зургаан сая найман зуун наян таван мянга нэг зуу) төгрөгийн төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам 2 дугаар хавсралт 1.3-д "Төсвийн байгууллага нь тодруулбал зохих мэдээллийг заавал тодруулна", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдах этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

- Бүрдэл дутуу анхан шатны баримт, хэрэгжилт хангалтгүй гэрээг үндэслэн зардал гаргасан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны дарга Д.Отгонсүрэн, нягтлан бодогч А.Батжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Т.ГАНДОЛГОР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090893



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 483/АУД-20 344

Улаанбаатар хот

НТМ-2026/185/ММ СТН-7423

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын вэб сайт боловсруулах үйлчилгээ авсан боловч уг хөрөнгийг байгууллагын биет бус хөрөнгөнд бүртгэн авч тайлагнаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдэж, 19,900,000.0 (арван есөн сая есөн зуун мянга) төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам 2 дугаар хавсралтын 1.3-д "Төсвийн байгууллага нь тодруулбал зохих мэдээллийг заавал тодруулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын веб сайт хийлгээд хүлээж аваагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдэж төлбөрийг шилжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны дарга Д.Отгонсүрэн, нягтлан бодогч А.Батжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Т.ГАНДОЛГОР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090899



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 487/А0290344

Улаанбаатар хот

МААТ-2026/185/НА-СНА-ТМБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мэргэжлийн болон хуулийн зөвлөх үйлчилгээг зөвлөх үйлчилгээний эрхгүй хувь хүнтэй гэрээ байгуулж 40,800,000.00 (дөчин сая найман зуун мянга) төгрөгийг зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-д "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4.4-д "тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага хангасан байх", 37 дугаар зүйлийн 37.2.4-д "үйл ажиллагааны салбар, газар зүйн байрлалд үндэслэн захиалагчийг тодорхойлсон байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдах этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Зөвлөх үйлчилгээний эрхгүй иргэнтэй гэрээ байгуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны дарга Д.Отгонсүрэн, нягтлан бодогч А.Батжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Т.ГАНДОЛГОР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090903



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 485/АУЗАОЗУУ

Улаанбаатар хот

НТМТ 2026/175) ИА - СТА - ТУС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын 2,617,017.00 (хоёр сая зургаан зуун арван долоон мянга арван долоо) төгрөгийн орлого, зарлагын гүйлгээнд анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй, няравын тайланг сар бүр бэлтгэн баталгаажуулаагүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Сар бүрийн бараа материалын орлого, зарлагын дүнгээр анхан шатны баримтыг үндэслэн няравын тайланг бэлтгээгүй, нягтлан бодогч хянаж баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны дарга Д.Отгонсүрэн, нягтлан бодогч А.Батжаргал март даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Т.ГАНДОЛГОР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090895



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 486 /А0230344

Улаанбаатар хот

НТТГ - 2026 / 185 / ДА - ТН - МЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилтанд ажлын гүйцэтгэл, тайланг үндэслэхгүйгээр хавсран ажилласны нэмэгдэл 2,365,040.00 (хоёр сая гурван зуун жаран таван мянга дөч) төгрөгийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажилтанд хавсруулан гүйцэтгүүлсэн ажлын нэмэгдэлийг ажлын тайлан, гүйцэтгэлд үндэслээгүй олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны дарга Д.Отгонсүрэн, нягтлан бодогч А.Батжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Т.ГАНДОЛГОР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090901



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 дугаар сарын 05

№ 77/АДЗД/2024

Улаанбаатар хот

11717-2024/185/НН-СНА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ВАЙЛД РЕЗОРТ жуулчны баазад заал түрээслэн 1,568,000.00 (нэг сая таван зуун жаран найман мянга) төгрөгийн хурал зохион байгуулсан зардал гарсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувлал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын алба илэрсэн зөрчлийн 1,568,000.00 (нэг сая гурван таван зуун жаран найман мянга) төгрөгийг Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны дарга Д.Отгонсүрэн, нягтлан бодогч А.Батжаргал нараар төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банк дахь НТАГ хүү торгуулийн орлогын IBAN440090100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 30-ны дотор Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны дарга Д.Отгонсүрэн, нягтлан бодогч А.Батжаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Т.ГАНДОЛГОР

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426110225



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 дугаар сарын 25

№ 78/АКЭЗДЗЧЧ

Улаанбаатар хот

ИТАГ-2026/185/НА-УНА-ТЧЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зочид төлөөлөгч хүлээн авах зардалд тусгасан 1,437,617.00 (нэг сая дөрвөн зуун гучин долоон мянга зургаан зуун арван долоо) төгрөгийг байгууллагын ажилтаны дансруу шилжүүлсэн, нотлох баримт байхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 1 дүгээр хавсралтын 1.3-д "Төсвийн байгууллага нь тодруулбал зохих мэдээллийг заавал тодруулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын алба илэрсэн зөрчлийн 1,437,617.00 (нэг сая дөрвөн зуун гучин долоон мянга зургаан зуун арван долоо) төгрөгийг Захирагчийн ажлын албаны дарга Д.Отгонсүрэн, нягтлан бодогч А.Батжаргал нараар төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын


¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110228

- газрын Төрийн сан банк дахь НТАГ.хүү торгуулийн орлогын
IBAN440090100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 30-ны дотор Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны дарга Д.Отгонсүрэн, нягтлан бодогч А.Батжаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Т.ГАНДОЛГОР

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар